



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 796

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 162,257,660.00 (нэг зуун жаран хоёр сая хоёр зуун тавин долоон мянга зургаан зуун жар) төгрөгийн балансын үнэ, 41,107,660.00 (дөчин нэгэн сая нэг зуун долоон мянга зургаан зуун жар) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгө (элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 5 нэрийн, нийт 41,107,660.00 (дөчин нэгэн сая нэг зуун долоон мянга зургаан зуун жар) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 10,513,855.00 (арван сая таван зуун арван гурван мянга найман зуун тавин тав) төгрөгөөр шинэчлэн тогтоож)-ийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003029

32-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглах хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох балансын нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил (жилээр)	Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр
Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг												
1	Кушетка	6/30/2021	ш	252,000.00	1	252,000.00	252,000.00	-	126,000.00	126,000.00	2	Хууль зүй, дотоод хэргийн яам
2	Хаалт /эмнэлгийн/	6/30/2021	ш	150,000.00	1	150,000.00	150,000.00	-	75,000.00	75,000.00	2	
3	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	12/17/2021	ш	545,760.00	1	545,760.00	545,760.00	-	272,880.00	272,880.00	2	
	Дүн				3	947,760.00	947,760.00	-		473,880.00		
Хууль зүй, дотоод хэргийн яам												
4	Компьютер (iMac)	12/17/2019	ш	3,650,900.00	5	18,254,500.00	18,254,500.00	-	912,725.00	4,563,625.00	1	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
	Дүн				5	18,254,500.00	18,254,500.00	-		4,563,625.00		
Хууль зүй, дотоод хэргийн яам												
5	Компьютер (iMac)	12/17/2019	ш	3,650,900.00	6	21,905,400.00	21,905,400.00	-	912,725.00	5,476,350.00	1	ХХЕГ-ын Зорчигчийн мэдээллийн төв
	Дүн				6	21,905,400.00	21,905,400.00	-		5,476,350.00		
Хууль зүй, дотоод хэргийн яам												
6	Таблет (Samsung Galaxy Tab Active 3 кейс, наалт хамт/	12/10/2024	ш	2,423,000.00	50	121,150,000.00	-	121,150,000.00				ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн алба
	Дүн				50	121,150,000.00		121,150,000.00				
	НИЙТ ДҮН					162,257,660.00 (нэг зуун жаран хоёр сая хоёр зуун тавин долоон мянга зургаан зуун жар)	41,107,660.00 (дөчин нэгэн сая нэг зуун долоон мянга зургаан зуун жар)	121,150,000.00 (нэг зуун хорин нэгэн сая нэг зуун тавин мянга)		10,513,855.00 (арван сая таван зуун арван гурван мянга найман зуун тавин тав)		